



**ХЭНГИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 76

Хэрлэн сум

Бор-Өндөр сумын Засаг даргын  
Тамгын газрын 3 дугаар багийн зохион  
байгуулагчийн сул орон тоонд  
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (25,6) авсан Эрдэнэчимэгийн Номинг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 3 дугаар багийн Багийн зохион байгуулагчийн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч Э.Номинг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА